



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ЦАГ УУР, ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР**

Жуулчны гудамж 5, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 41 52, Факс: (976-11) 32 66 11,
Цахим шуудан: info@namem.gov.mn

2025.07.30 № 01/501
танай _____-ны № _____-т

Санал хүргүүлэх тухай

Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн “Тогтоолд хавсралт нэмэх, тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай” 84 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн үйлчилгээний мэргэжлийн бусад байгууллагын албан тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт”-аар төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах төрийн үйлчилгээний албан тушаалаас (ТҮ) төрийн үйлчилгээний мэргэжлийн албан тушаалын (ТҮМ) зэрэглэлд 2024 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн шилжсэн.

Төрийн үйлчилгээний мэргэжлийн албан тушаалын зэрэглэлд шилжих үед ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын зарим албан тушаалын нэршил орхигдсон, албан тушаалын цалин буурсан, албан тушаалын эрэмбэ алдагдсан байх тул Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг хүргүүлж байна.

Холбогдох мэдээллийг хавсаргав.

Хавсралт ⁹..... хуудастай.

ДАРГА




Э.БАТТУЛГА

152250286

d:\2025\тоот\07.30-501.docx

Цаг уур, орчны шинжилгээний газрын
2025 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн
01/501 дүгээр албан бичгийн хавсралт



Төсөл

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралтаар баталсан “Төрийн үйлчилгээний мэргэжлийн бусад байгууллагын албан тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт”-ын “ТҮМ-8” зэрэглэлийн “Удирдах” баганад “5. Цаг уур, орчны шинжилгээний газрын харьяа байгууллагын нэгжийн дарга” гэж нэмсүгэй.

2. Мөн “ТҮМ-7” зэрэглэлийн “Гүйцэтгэх” баганы “1.Цаг уур, орчны шинжилгээний газрын ерөнхий инженер, урьдчилан мэдээлэхийн ерөнхий технологич инженер,” гэснийг “1.Цаг уур, орчны шинжилгээний газрын ерөнхий инженер, технологич инженер, ахлах мэргэжилтэн” гэж, “ТҮМ-6” зэрэглэлийн “Гүйцэтгэх” баганы “4.Цаг уур, орчны шинжилгээний газрын инженер” гэснийг “4.Цаг уур, орчны шинжилгээний газрын инженер, мэргэжилтэн” гэж, “5.Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн байгаль орчны ахлах шинжээч, ахлах мэргэжилтэн” гэснийг “5.Цаг уур, орчны шинжилгээний газрын харьяа байгууллагын ерөнхий инженер, технологич инженер, ахлах инженер, ахлах мэргэжилтэн, ахлах шинжээч” гэж, “ТҮМ-5” зэрэглэлийн “Гүйцэтгэх” баганы “6.Цаг уур, орчны шинжилгээний газрын мэргэжилтэн” гэснийг “Цаг уур, орчны шинжилгээний газрын харьяа байгууллагын инженер, мэргэжилтэн, шинжээч, ахлах техникч” гэж, “ТҮМ-4” зэрэглэлийн “Гүйцэтгэх” баганы “6.Аймаг, хотын Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн инженер, мэргэжилтэн, байгаль орчны шинжээч, газгенераторч, цаг уурын ажиглагч” гэснийг “Цаг уур, орчны шинжилгээний газрын харьяа байгууллагын газгенераторч, ажиглагч, техникч” гэж, ТҮМ-6” зэрэглэлийн “Гүйцэтгэх” баганы “1-11” гэсэн дугаарлалтыг “1-8” гэж, “ТҮМ-5” зэрэглэлийн “Гүйцэтгэх” баганы “1-11” гэсэн дугаарлалтыг “1-7” тус тус өөрчилсүгэй.

3. Мөн “ТҮМ-7” зэрэглэлийн “Удирдах” баганад “4.Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн нэгжийн дарга”, “5.Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн нэгжийн дарга”, “6.Нислэгийн цаг уурын төвийн нэгжийн дарга”, “7.Аймаг, нийслэлийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн нэгжийн дарга”, “ТҮМ-6” зэрэглэлийн “Гүйцэтгэх” баганы “6.Ус, цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн ерөнхий инженер, ахлах мэргэжилтэн”, “7.Нислэгийн цаг уурын төвийн ерөнхий инженер, урьдчилан мэдээлэхийн ерөнхий технологич инженер, ахлах мэргэжилтэн”, “10.Аймаг, нийслэлийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн урьдчилан мэдээлэхийн технологич инженер”, “ТҮМ-5” зэрэглэлийн “Гүйцэтгэх” баганад “7.Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн байгаль орчны шинжээч, мэргэжилтэн, инженер”, “8.Ус, цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн ахлах инженер, мэргэжилтэн”, “9.Нислэгийн цаг уурын төвийн инженер, мэргэжилтэн”, “11.Аймаг, нийслэлийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн технологич инженер, урьдчилан мэдээлэхийн инженер, ахлах мэргэжилтэн, байгаль орчны ахлах шинжээч” гэснийг тус тус хассугай.

4. Энэхүү тогтоолыг баталсан өдрөөс дагаж мөрдсүгэй.

ЕРӨНХИЙ САЙД

Г.ЗАНДАНШАТАР

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД

Т.АУБАКИР

Санал хүргүүлэх тухай

Засгийн газрын 2024 оны "Тогтоолд хавсралт нэмэх, тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай" 84 дүгээр тогтоолоор Засгийн газрын 2023 оны "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай" 240 дүгээр тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулсан.

Уг тогтоолоор Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын төрийн үйлчилгээний албан тушаал төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах төрийн үйлчилгээний албан тушаалаас (ТҮ) төрийн үйлчилгээний мэргэжлийн албан тушаалын (ТҮМ) зэрэглэлд 2024 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн шилжсэн.

Энэхүү тогтоолд ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын зарим албан тушаалын нэршил орхигдсон, ТҮ зэрэглэлээс ТҮМ зэрэглэлд шилжихэд зарим албан тушаалын цалин буурсан, албан тушаалын эрэмбэ алдагдсан байгаа тул Засгийн газрын 2024 оны 240 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралт "Төрийн үйлчилгээний мэргэжлийн бусад байгууллагын албан тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт"-д нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг хүргүүлж байна.

Хууль, журмын дагуу шийдвэрлэж өгөхийг хүсье.

Холбогдох мэдээллийг хавсаргав.

Хавсралт хуудастай.

САЙД

Б.БАТБААТАР

ТАНИЛЦУУЛГА

Цаг уур, орчны шинжилгээний газар нь харьяа 25 байгууллагатай бөгөөд батлагдсан орон тоо 1893. Үүнээс төрийн захиргааны албан тушаалд 29, шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний албан тушаалд 33, төрийн үйлчилгээний мэргэжлийн албан тушаалд 1736, бусад төрийн үйлчилгээний албан тушаалд 33 албан хаагч ажиллаж байна.

Ус цаг уур, орчны хяналт, шинжилгээний салбарын 1736 албан тушаал Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн “Тогтоолд хавсралт нэмэх, тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай” 84 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн үйлчилгээний мэргэжлийн бусад байгууллагын албан тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт”-аар нийтлэг төрийн үйлчилгээнээс төрийн үйлчилгээний мэргэжлийн зэрэглэлд 2024 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн шилжсэн.

Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхэд ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын зарим албан тушаалын нэршил орхигдсон, албан тушаалын цалин буурсан, албан тушаалын эрэмбэ алдагдсан зэрэг дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын албан тушаалын зэрэглэл ТҮ-ээс ТҮМ-д шилжихэд тус газрын харьяа байгууллагын 62 нэгжийн дарга нарын албан тушаалын цалин 77,000 төгрөгөөр, аймаг, нийслэлийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 80 гаруй технологич инженерийн албан тушаалын үндсэн цалин 3,000 төгрөгөөр тус тус буурсан.

2. Цаг уур орчны шинжилгээний газрын ахлах мэргэжилтэн, харьяа байгууллагын ахлах техникч, техникч, усны ажиглагчийн албан тушаал дээрх тогтоолын албан тушаалын жагсаалтад орхигдуулсан.

3. Цаг уур, орчны шинжилгээний газрын технологич инженер, ерөнхий инженер, инженерийн албан тушаалын зэрэглэл харьяа байгууллагын дээрх албан тушаалын зэрэглэлээс 1 зэрэглэлээр дээр байгаа боловч Цаг уур, орчны шинжилгээний газрын мэргэжилтний албан тушаалын зэрэглэл нь харьяа байгууллагын мэргэжилтний албан тушаалын зэрэглэлтэй ижил тогтоосон нь албан тушаалын тэгш бус байдалд хүргэж байна.

4. Аймаг, нийслэлийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн инженер, мэргэжилтний албан тушаалыг ажиглагч, газгенераторчийн албан тушаалтай адилтган авч үзэж ТҮМ-4 зэрэглэлд хамааруулсан нь албан тушаалын эрэмбэ алдагдахад хүрч, ажлын байрны чиг үүрэг, гүйцэтгэх ажил үйлчилгээний зөрүү гарч, албан хаагчдын дунд үл ойлголцол үүсэхэд хүргэж байна.

Иймд “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралтаар баталсан “Төрийн үйлчилгээний мэргэжлийн бусад байгууллагын албан тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт”-д дараах өөрчлөлтийг оруулах зайлшгүй шаардлага үүссэн гэж үзэж байна.

----oOo----

Засгийн газрын 2023 оны 06дугаар
сарын 21-ний өдрийн 240 дүгээр
тогтоолын 7 дугаар хавсралт

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЭРГЭЖЛИЙН БУСАД БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ТУШААЛЫН ЗЭРЭГЛЭЛ,
ТҮҮНД ХАМААРАХ АЛБАН ТУШААЛЫН ЖАГСААЛТ-д нэмэлт өөрчлөлт оруулах санал

№	Зэрэглэл	Албан тушаал		
		Удирдах	Гүйцэтгэх	
		2	3	
1.	ТҮМ-10	1.Үндэсний төв архивын захирал		
2.	ТҮМ-9	1.Төрийн архивын дарга 2.Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн захирал 3.Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн захирал 4.Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн захирал 5.Нислэгийн цаг уурын төвийн дарга 6.Аймаг, нийслэлийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга		
3.	ТҮМ-8	1.Үндэсний төв архивын нэгжийн дарга, салбар архивын дарга 2.Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн чанар, техникийн менежер, нийслэлийн лабораторийн дарга 3.Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн ерөнхий эмч 4.Нислэгийн цаг уурын төвийн аюулгүй байдал, чанарын менежер		

		5. Цаг уур, орчны шинжилгээний газрын харьяа байгууллагын нэгжийн дарга		
4.	ТҮМ-7	1.Төрийн архив, салбар архивын нэгжийн дарга 2.Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн эрхлэгч, нэгжийн дарга 3.Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн эрхлэгч, нэгжийн дарга 4.Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн нэгжийн дарга 5.Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн нэгжийн дарга 6.Нислэгийн цаг уурын төвийн нэгжийн дарга хасах 7.Аймаг, нийслэлийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн нэгжийн дарга	1.Цаг уур, орчны шинжилгээний газрын ерөнхий инженер, урьдчилан мэдээлэхийн ерөнхий технологич инженер, ахлах мэргэжилтэн 2.Нислэгийн цаг уурын төвийн аюулгүй байдал, чанарын хяналтын ахлах мэргэжилтэн 3.Ерөнхий нягтлан бодогч 4.Нийслэлийн лабораторийн чанарын менежер, техникийн менежер	
5.	ТҮМ-6		1.Төрийн архивын эрдэм шинжилгээний ахлах ажилтан, ахлах зааварлагч-арга зүйч, ахлах архивч, ахлах сэлбэн засагч, ахлах архивч-операторч, хадгалалт хамгаалалтын технологич, мэдээллийн технологийн ажилтан 2.Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн ахлах шинжээч 3.Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн ахлах шинжээч, судлагч 4.Цаг уур, орчны шинжилгээний газрын инженер, мэргэжилтэн 5. Цаг уур, орчны шинжилгээний газрын харьяа байгууллагын ерөнхий инженер,	

		технологич инженер, ахлах инженер, ахлах мэргэжилтэн, ахлах шинжээч 5.Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн байгаль орчны ахлах шинжээч, ахлах мэргэжилтэн, технологич инженер 6.Ус, цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн ерөнхий инженер, ахлах мэргэжилтэн 7.Нислэгийн цаг уурын төвийн ерөнхий инженер, урьдчилан мэдээлэхийн ерөнхий технологич инженер, ахлах мэргэжилтэн 8. Нийслэлийн лабораторийн ахлах шинжээч 9. Аймаг, орон нутгийн лабораторийн эрхлэгч, чанарын менежер, 10.Аймаг, нийслэлийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн урьдчилан мэдээлэхийн технологич инженер 11.Нягтлан бодогч	
6.	ТҮМ-5	1.Төрийн архивын эрдэм шинжилгээний ажилтан, зааварлагч-арга зүйч, архивч, кино дүрс бичлэгийн инженер, сэлбэн засагч, зохион байгуулагч 2.Төрөлжсөн болон тусгай архивын ахлах зааварлагч-арга зүйч, ахлах архивч, ахлах архивч-операторч, хадгалалт хамгаалалтын технологич 3.Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн шинжээч 4.Сорьц тогтоох лабораторийн химич-шинжээч, хэмжил зүйн техникч, 5.Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн дээж хүлээн авагч эмч, судлагч	

		6.Цаг уур, орчны шинжилгээний газрын мэргэжилтэн 6. Цаг уур, орчны шинжилгээний газрын харьяа байгууллагын инженер, мэргэжилтэн, шинжээч, ахлах техникч 7.Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн байгаль орчны шинжээч, мэргэжилтэн, инженер 8.Ус, цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн ахлах инженер, мэргэжилтэн 9.Нислэгийн цаг уурын төвийн инженер, мэргэжилтэн 10.Нийслэлийн лабораторийн шинжээч, дээж хүлээн авагч 11.Аймаг, нийслэлийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн технологич инженер, урьдчилан мэдээлэхийн инженер, ахлах мэргэжилтэн, байгаль орчны ахлах шинжээч	
7.	ТҮМ-4	1.Төрийн архивын микрофильмийн техникч, микрофиш, фильмийн хальс боловсруулагч, сан хөмрөгч, уншлагын танхимын эрхлэгч, архивч-операторч, архивч-эх бэлтгэгч 2.Яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын архив, бичиг хэргийн эрхлэгч 3.Төрөлжсөн болон тусгай архивын зааварлагч-арга зүйч, архивч, сэлбэн засагч, архивч-операторч 4.Сорьц тогтоох лабораторийн сорьц дарагч, үнэт металл хайлагч 5.Аймаг, орон нутгийн лабораторийн шинжээч, дээж авагч, их эмч, судлагч,	

			6. Цаг уур, орчны шинжилгээний газрын харьяа байгууллагын Аймаг, хотын Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн инженер, мэргэжилтэн, байгаль орчны шинжээч, газгенераторч, цаг уурын ажиглагч, техникч 7.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын байгууллагын нийгмийн ажилтан, сэтгэл зүйч	
8.	ТҮМ-3		1.Төрийн архивын дэвтэрлэгч, хэвлэгч, химич-лаборант, галын болон хамгаалалтын системийн техникч, баримт ариутгагч 2.Яам, агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГ-аас бусад байгууллагын архив, бичиг хэргийн эрхлэгч, архивч 3.Лабораторийн лаборант, техникч, үстөрөгчийн баллон цэнэглэгч	
9.	ТҮМ-2		1.Лабораторийн автоклавчин	
10.	ТҮМ-1		1.Лабораторийн шил угаагч, ариутгагч	